

ХӨРӨНГӨ АКТАЛСНААС БОЛОН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТҮРЭЭСЭЭС
ОЛСОН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2025.12.25

Хэрлэн сум

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 тогтоолын хавсралтын 8.3."Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана" гэж заасны дагуу демонтажаар гарсан хаягдал төмрийг зохих журмын дагуу 23.2 сая төгрөгөөр худалдан борлуулсан.

Нийт 4 үүрэн операторын компаниудтай хийсэн гуравласан гэрээний үндсэн түрээсийн төлбөр болох 26.4 сая төгрөг татан төвлөрүүлсэн. Мөн "ДБЭХС" ТӨХК-ийн Эрчим хүч борлуулалтын хэлтсийн байрны В1 буюу фитнесийн түрээсийн орлого 11.4 сая төгрөг, үйлдвэрийн цайны газрын түрээсийн төлбөр 12.0 сая төгрөг төвлөрсөн байна.

Тус компанийн спорт заал болон юнивишний шон түрээсийн төлбөр нь нийт 27.4 сая төгрөг тус тус компанийн орлого болгон бүртгэлд тусган ажилласан.